ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“АЗЗА нэгтгэл” ТӨХК-ийн Дархан салбарын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/1/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер:У.Батсүрэн Утас:70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Ахлах аудитор: Х.Сувдмаа Утас: 70373089 Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.09 № 27

танай _____-ны №_____ -т

"АЗЗА НЭГТГЭЛ" ТӨХК-НИЙ ДАРХАН САЛБАРЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТБОЛД ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "АЗЗА нэгтгэл" ТӨХК-ийн Дархан салбарын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 159,860.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 71 дүгээр зүйлийн 71.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, "АЗЗА нэгтгэл" ТӨХК-ийн "Дархан салбарын үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Компани гүйцэтгэлээр 1,609,445.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,738,617.0 мянган төгрөгийн зардал гарган, 129,171.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бол өмнөх онтой харьцуулбал 264,411.0 мянган төгрөг буюу 32.8 хувиар буурсан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,609,445.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 1,868,554.7 мянган төгрөг буюу 53.7 хувиар тасарсан нь улсын чанартай зам засвар арчлалтын орлого 1,402,115.0 мянган төгрөгөөр, ээлжит засварын болон үйл ажиллагааны бусад орлого 1,868,665.8 мянган төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

4526050028

2

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус компанийн авлага, өр төлбөрийн дансанд насжилт өндөртэй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 1 иргэний 278.4 мянган төгрөгийн, 6 аж ахуйн нэгж байгууллагын 92,994.6 мянган төгрөгийн, нийт 93,273.0 мянган төгрөгийн авлага болон 2009 онд үүссэн Кувейтийн сангийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн автомашин, тоног төхөөрөмжийн үнийн 812,472.3 мянган төгрөгийн өр төлбөр тус тус бүртгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 220 дугаар тогтоолоор авто замын засвар арчлалтын компаниудыг нийлүүлэн "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" төрийн өмчит хувьцаат компани болгох шийдвэр гарснаар тус компани нь дээрх компанийн охин компани болсон байна.

Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 100 хувиар тайлагнасныг Зам тээврийн хөгжлийн яамнаас 87.75 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Мөрний дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	19,636,547.69	21,646,288.21
1.1.02	Дансны авлага	345,811,269.58	563,881,536.93
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	6,760,581.53	
1.1.04	Бусад авлага	278,375.90	
1.1.06	Бараа материал	109,355,901.32	150,115,007.67
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	**481,842,676.02**	**735,642,832.81**
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	903,532,400.56	765,708,797.57
1.2.02	Биет бус хөрөнгө	489,873,333.49	489,353,131.31
1.2.03	Биологийн хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**1,393,405,734.05**	**1,255,061,928.88**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**1,875,248,410.07**	**1,990,704,761.69**
2	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	**Богино хугацаат өр төлбөр**	-	-
2.1.1.01	Дансны өглөг	67,049,896.65	413,276,825.40
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	325,991,096.34	285,612,011.58
2.1.1.04	НДШ - ийн өглөг	129,250,013.82	86,935,783.07
2.1.1.05	Богино хугацаат зээл	1,387,705.67	
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	17,439,000.00	
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**541,117,712.48**	**785,824,620.05**
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	812,472,334.00	
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.06	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**812,472,334.00**	**0.00**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**1,353,590,046.48**	**785,824,620.05**
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	582,966,824.33	582,966,825.33
2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	242,380,302.88	242,380,303.88
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	704,928,568.65	1,517,400,902.65
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(1,008,617,332.27)	(1,137,867,888.22)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	(393,582,407.19)	(129,171,797.23)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(615,034,925.08)	(1,008,696,090.99)
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**521,658,363.59**	**1,204,880,141.64**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**1,875,248,410.07**	**1,990,704,761.69**

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
01	**Борлуулалтын орлого (цэвэр)**	**1,158,689,236.58**	**1,609,445,244.85**
02	**Борлуулалтын өртөг**	**1,295,240,864.02**	**1,402,631,817.24**
03	**Нийт ашиг(алдагдал)**	**(136,551,627.44)**	**206,813,427.61**
04	Түрээсийн орлого	-	-
05	Хүүний орлого	-	215,939.47
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	835,340.91	
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	248,016,294.61	241,823,801.05
11	Санхүүгийн зардал	4,227,616.47	1,067,365.35
12	Бусад зардал		93,288,403.97
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(2,538,281.22)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	(3,083,928.36)	
17.1	Олз, гарзын дүн	(5,622,209.58)	
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)**	**(393,582,407.19)**	**(129,150,203.29)**
19	Орлогын татварын зардал	-	21,593.94
2.1.2.6	05-Бусад орлого	-	-
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**(393,582,407.19)**	**(129,171,797.23)**
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**(393,582,407.19)**	**(129,171,797.23)**
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2024 оны 01 сарын 01-ээр үлдэгдэл	582,966,824.33	-	169,381,142.45	704,928,568.65	(614,478,074.63)	842,798,460.80
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга	-	-	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	(556,850.45)	(556,850.45)
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(393,582,407.19)	(393,582,407.19)
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	72,999,160.43	-	-	72,999,160.43
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	582,966,824.33	-	242,380,302.88	704,928,568.65	(1,008,617,332.27)	521,658,363.59
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга	-	-	-		(78,758.72)	(78,758.72)
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(129,171,797.23)	(129,171,797.23)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	812,472,334.00	-	812,472,334.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-		-	-	-
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	582,966,824.33	-	242,380,302.88	1,517,400,902.65	(1,137,867,888.22)	1,204,880,141.64

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	**-**	**-**
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**1,421,376,296.26**	**1,224,852,942.07**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,409,946,138.06	1,164,753,998.17
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	105,403.00	
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	11,324,755.20	60,098,943.90
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**1,385,610,876.50**	**1,220,443,304.55**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	415,583,424.91	692,891,227.34
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	150,820,890.58	205,094,206.87
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	412,019,465.30	127,979,235.46
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	11,209,937.47	8,790,778.45
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	156,540,911.10	70,645,750.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	3,515,076.71	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	26,338,122.52	21,179,067.10
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	209,583,047.91	93,863,039.33
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**35,765,419.76**	**4,409,637.52**
2.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**2,538,281.22**	**-**
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	2,538,281.22	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**8,670,000.00**	**2,399,900.00**
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,670,000.00	2,399,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,000,000.00	
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(6,131,718.78)**	**(2,399,900.00)**
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	**-**	**-**
3.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**15,000,000.00**	**-**
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	15,000,000.00	
3.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**40,000,000.00**	**-**
3.2.1	Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	40,000,000.00	
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(25,000,000.00)**	**-**
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**4,633,700.98**	**2,009,740.52**
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,002,846.71	19,636,547.69
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,636,547.69	21,646,288.21

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Үйлчилгээний орлого	930,411,854.00	1,225,920,000.00	1,198,006,244.85	(27,913,755.15)	97.7
Борлуулалтын орлого	225,862,265.00			-	
Эрчмийн орлого	2,415,118.00			-	
Ээлжит засварын орлого		1,402,115,000.00		(1,402,115,000.00)	-
Үйл ажиллагааны бус бусад орлого	835,341.00	849,965,000.00	411,439,000.00	(438,526,000.00)	48.4
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,159,524,578.00	3,478,000,000.00	1,609,445,244.85	(1,868,554,755.15)	46.3
Бусад орлого	-	-	-	-	
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	**1,159,524,578.00**	**3,478,000,000.00**	**1,609,445,244.85**	**(1,868,554,755.15)**	46.3
Цалин хөлс	544,819,825.00	1,125,610,000.00	803,203,052.47	(322,406,947.53)	71.4
АО-аас НД-шимтгэлд төлөх зардал		163,040,000.00	103,330,000.00	(59,710,000.00)	63.4
Материалын зардал	689,412,120.00	1,071,659,000.00	289,099,000.00	(782,560,000.00)	27.0
Ашиглалтын зардал	6,763,057.00	20,598,000.00	7,678,000.00	(12,920,000.00)	37.3
Засвар үйлчилгээний зардал	9,321,850.00	10,324,000.00	1,676,681.00	(8,647,319.00)	16.2
Байгууллагын үйл ажиллагааг хангах зардалд		387,735,000	133,207,000	(254,528,000.00)	34.4
Ажиллагсадтай холбоотой зардал	11,687,200.00	101,975,000.00	27,715,000.00	(74,260,000.00)	27.2
Сургалт томилолтын зардалд		24,759,000.00	8,240,000.00	(16,519,000.00)	33.3
Элэгдлийн зардал	96,950,018.00	108,596,000.00	156,533,714.26	47,937,714.26	144.1
Тээврийн зардал	34,647,050.00	37,000,000.00	4,672,000.00	(32,328,000.00)	12.6
Тээврийн хэрэгслийн түрээсийн зардал		45,000,000.00	27,400,000.00	(17,600,000.00)	60.9
Татвар даатгал төлбөр хураамжийн зардал	441,726.00	193,327,000.00	138,529,000.00	(54,798,000.00)	71.7
ХАБЭА-ЗАРДАЛ		40,713,000.00	33,511,000.00	(7,202,000.00)	82.3
ТУЗ-ийн зардал	14,646,000.00			-	
Бусад зардал	144,418,140.00	37,365,000.00	3,822,594.35	(33,542,405.65)	10.2
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	**1,553,106,986.00**	**3,367,701,000.00**	**1,738,617,042.08**	**(1,629,083,957.92)**	51.6
ОЛЗ ГАРЗЫН ДҮН	-	-	-	-	
НИЙТ АШИГ/АЛДАГДАЛ	**(393,582,408.00)**	**110,299,000.00**	**(129,171,797.23)**	**(239,470,797.23)**	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 829,911.3 мянган төгрөгийн дараах 2 алдааг[1] аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тус компани нь 2017 онд хэрэгжсэн түрээсийн 17,439.0 мянган төгрөгийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүйгээс 2025 оны санхүүгийн тайланд урьдчилж орсон орлого дансанд үлдэгдлээр тайлагнасан,
2. Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2009 онд нийлүүлсэн 812,472.3 мянган төгрөгийн автомашин, тоног төхөөрөмжийг дүрмийн санд бүртгэх ТӨХ-ны 2009 оны 3/1699 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс урт хугацаат өр төлбөрт бүртгэсэн зэрэг нь НББОУС1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Толилуулга" зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлангийн урьдчилж орсон орлого, урт хугацаат өр төлбөрийг бууруулж, орлого үр дүнгийн тайланд орлогоор бүртгүүлж, эздийн өмчийн бусад хэсгийг нэмэгдүүлж залруулав. Мөн аудитаар нийт 159,860.0 мянган төгрөгийн зөрчил[2]-д 252.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 159,608.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага нь тайлант онд албан томилолтоор ажилласан 5 албан хаагчид 252.0 мянган төгрөгийн хоол, унааны нөхөх төлбөрийг давхардуулан олгож, компанийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно",* Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д *"Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ"*, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.1-т *"Хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх",* 84.4.2-т *"Үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1. <u>Илрүүлэлт:</u>

Тус компанийн авлагын дансанд насжилт өндөртэй, 5-аас дээш жил болсон 6 аж ахуйн нэгж байгууллагын 92,994.6 мянган төгрөгийн тооцоо нийлээгүй авлага байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах",* Төрийн болон нутгийн өмчийн

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

[2] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д *"Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д заасныг баримтлан, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, насжилт өндөртэй авлагыг тодорхой хувиар бууруулах, хариуцах эзэн тодорхойгүй авлагыг эрх бүхий байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх

2. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тус компанийн өр төлбөрийн дансанд 2019 онд үүссэн насжилт өндөртэй 66,613.4 мянган төгрөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өр төлбөр бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д *"Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасныг хэрэгжүүлэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, хуваарь гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 56 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д *"Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ"* гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д заасны дагуу ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх, шаардлагагүй хөрөнгийг актлах, данснаас хасах зэрэг саналыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тус байгууллага нь эд хариуцагчийг ажилд шинээр орох, ажлаас гарах зэрэгт бараа материалын тооллого явуулдаггүй, бараа материал үнэ бүхий зүйлийг хариуцаж буй

ажилтнуудтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2-т *"Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 75 дугаар зүйлд "*Ажилтны эд хөрөнгийн бүрэн хариуцлага"-ын гэрээ байгуулж болно, 129 дүгээр зүйлд "Эд хөрөнгийн хариуцлага, түүнийг хүлээлгэх үндэслэл", 131 дүгээр зүйлд "Эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 75, 129, 131 дүгээр зүйлд заасны дагуу эд хариуцагч солигдох үед шийдвэр гарган хөрөнгийн тооллогыг заавал хийж, эд хариуцагчтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж ажиллах

Эдгээр зөвлөмжөөс гадна тайлангийн 4.4.1 дэх хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[3]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[3] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн
Тус байгууллагын 2025 оны жилийн эцсийн байдлаар урьдчилж орсон орлого дансанд 17.4 сая төгрөгийн үлдэгдэл байна.	1	812,472.3			1	812,472.3	1	812,472.3	-	-	-	-
Арабын эдийн засгийн Кувейтийн сангийн хөрөнгөөр бий болсон 812.5 сая төгрөгийн машин механизм, тоног төхөөрөмжийг ТӨХ-ноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлээгүй урт хугацаат өр төлбөр дансанд бүртгэсэн байна	1	17,439.0			1	17,439.0	1	17,439.0				
Дүн	**2**	**829,911.3**			**2**	**829,911.3**	**2**	**829,911.3**	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Албан тушаалтны too	Too	Дүн
Тайлант онд албан томилолтоор ажилласан 5 албан хаагчид 252.0 мянган төгрөгийн хоол, унааны нөхөх төлбөрийг давхардуулан олгож, компанийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	252.0	1	252.0	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 56 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Тус байгууллага нь эд хариуцагчийг ажилд шинээр орох, ажлаас гарах зэрэгт бараа материалын тооллого явуулдаггүй, бараа материал үнэ бүхий зүйлийг хариуцаж буй ажилтнуудтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж ажиллаагүй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тус компанийн авлагын дансанд насжилт өндөртэй, 5-аас дээш жил болсон 6 аж ахуйн нэгж байгууллагын 92,994.6 мянган төгрөгийн тооцоо нийлээгүй авлага байна	1	92,994.6	-	-	-	-	1	92,994.6	-	-	-	-
Тус компанийн өр төлбөрийн дансанд 2019 онд үүссэн насжилт өндөртэй 66,613.4 мянган төгрөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өр төлбөр бүртгэлтэй байна	1	66,613.4	-	-	-	-	1	66,613.4				
Дүн	**5**	**159,860.0**	**1**	**252.0**	**-**	**-**	**4**	**159,608.0**	**-**	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 13,555.1 мянган төгрөгийн 2 гүйлгээ, мөн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх 2 мэдээллийг хугацаа хоцроож, мэдээлсэн байна.	1	13,555.1	-	-	-	-	1	13,555.1	-	-	-	-
Дүн	**1**	13,555.1	**-**	**-**	**-**	**-**	**1**	13,555.1	**-**	-	-	-